

БАТЛАВ:

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Г.НАНДИНЖАРГАЛ

“УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
ЯАМ, АГЕНТЛАГАЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИД ХЭРЭГЛЭГЧИЙН
ҮНЭЛГЭЭ ХИЙХ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗӨВЛӨХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2020 оны ...р сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

№	Агуулга	Даалгавар
1.	Зөвлөх үйлчилгээний нэр	“Сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлагийн үйлчилгээний чанар, хүртээмжид хэрэглэгчийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ”-ний санал асуулга.
2.	Захиалагч газар, хэлтсийн нэр	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
3.	Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа	Хугацаа: 1 сар Эхлэх: 2020 оны ... дүгээр сарын ... -ны өдөр Дуусах: 2020 оны ... дүгээр сарын ... -ны өдөр
4.	Зөвлөх үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.12 дахь, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх, 20.2 дахь, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталсан Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын 2.3 дахь, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6 дахь, 9.7 дахь, 9.8 дахь, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамжийг тус тус үндэслэнэ.
5.	Судалгааны зорилго	Хэрэглэгчийн үнэлгээний зорилго нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн захиргааны төв байгууллага Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, төрийн захиргааны байгууллага Ашигт малтмал, газрын тосны газраас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.
6.	Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ажил	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэнэ. Энэхүү зорилгын хүрээнд бодлого, үйл ажиллагаа иргэдэд хүрсэн байдлыг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар иргэдийн саналыг авах, судлах, иргэдээс авсан санал асуулгын дунд үндэслэн үзүүлэх үйлчилгээг сайжруулах,

		цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.
7.	Санал болгож буй арга зүй	Санал асуулга, социологийн судалгаа гэх мэт боломжит аргуудыг хэрэглэнэ.
8.	Зөвлөх үйлчилгээний ажлын хүрэх үр дүн болон хэрхэн ашиглах талаар төсөөлөл	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүн үр нэлөөг шууд хүргэгч “хэрэглэгч”-ийн 1-ээс 1.2 хувь буюу Нийслэл дэх хуулийн этгээдийн ажилтнууд болон мэргэжлийн төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөлөл 500 гаруй иргэдийг хамруулна. Тайлангийн үр дүнг геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хэрэглэгчдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө, стратеги боловсруулахад ашиглана.
9.	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага	Хөндлөнгийн үнэлгээ хийх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> Судалгаа болон үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд байх (судалгааны хүрээлэн, төрийн бус байгууллага, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд); Судалгаа ба үнэлгээний чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, үүний дотор хэрэглэгчийн үнэлгээг хийж байсан туршлага нь давуу тал болно; Санхүүгийн болон хүний нөөцийн чадавхитай байх; Үнэлгээг удирдамжинд заасан хугацаанд хийж гүйцэтгэх чадвартай байх; Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын талаар мэдлэгтэй байх.
10.	Судалгааны тайлангийн үе шат	<p><u>Эхлэлтийн тайлан:</u> Түүвэр сонгох стратеги, мэдээлэл цуглуулах арга, нарийвчилсан ажлын төлөвлөгөө зэргийг тусгасан байна. Гэрээ байгуулагдсанаас 1 долоо хоногийн дотор Захиалагчид хүлээлгэн өгнө.</p> <p><u>Дунд хугацааны тайлан:</u> Дунд хугацааны тайлан нь арга зүй, үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж зэргийг багтаасан 30 хуудаснаас хэтрэхгүй хэмжээтэй байна. (Тайлангийн ерөнхий бүтцийг нарийвчилсан удирдамжийн бүлэг 3-аас харна уу). Гэрээ байгуулагдсанаас 3 долоо хоногийн дотор Урьдчилсан тайланд захиалагч байгууллагын саналыг авч, сайжруулах ажил гүйцэтгэнэ.</p> <p><u>Эцсийн тайлан:</u> Захиалагч байгууллагаас авсан саналыг тусган тайланг эцэслэж, хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээлгэж өгнө. Гэрээ байгуулагдсанаас 4 долоо хоногийн дотор эцсийн тайланг Захиалагчид хүлээлгэн өгнө.</p>